



Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн
захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын
2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үйл
ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр баталсан 29/06 дугаар удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2025 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үйл ажиллагаанд 208 байгууллага нь 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 8432 мэдээлэл байршуулах ёстойгоос 95,8% буюу 8081 мэдээллийг хуулийн хугацаанд, 3% буюу 252 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 1,2% буюу 99 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 95,8% гарлаа.



Мэдээлэл хугацаандаа байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



2025 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны улирлын мэдээг хуулийн хугацаанд илгээлт 83,7% буюу 170 байгууллага, хугацаа хоцорч илгээсэн 0,5% буюу 1 байгууллага, огт илгээгүй 15,3% 31 байгууллага, хянагдаагүй 0,5% буюу 1 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд хамаарахгүй 5 байгууллага байна.

Улирлын мэдээ илгээлтийг салбар тус бүрээр авч үзвэл:

Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Боловсролын салбарын 82 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 3444 мэдээлэл байршуулах ёстойгоос 3345 мэдээллийг хуулийн хугацаанд, 75 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 байгууллага 24 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,1 % гарлаа.

Соёлын салбарын 23 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 966 мэдээлэл байршуулах ёстойгоос 939 мэдээллийг хуулийн хугацаанд, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 байгууллага 3 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,2% гарлаа.


Эрүүл мэндийн салбарын 21 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 718 мэдээлэл байршуулах ёстойгоос 689 мэдээллийг хуулийн хугацаанд, 21 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 8 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 96% гарлаа.

Орон нутгийн төсвийн 48 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 2016 мэдээлэл байршуулах ёстойгоос 1934 мэдээллийг хуулийн хугацаанд, 65 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 байгууллага 17 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 95,9% гарлаа.


20 төрийн сан 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 780 мэдээлэл байршуулах ёстойгоос 720 мэдээллийг хуулийн хугацаанд, 57 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 3 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92,3% гарлаа.

Орон нутгийн өмчит 14 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 508 мэдээлэл байршуулах ёстойгоос 454 мэдээллийг хуулийн хугацаанд, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 байгууллага 44 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 89,4%.

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны улирлын мэдээг хуулийн хугацаанд илгээлт 83,7% буюу 170 байгууллага, хугацаа хоцорч илгээсэн 0,5% буюу 1 байгууллага, огт илгээгүй 15,3% 31 байгууллага, хянагдаагүй 0,5% буюу 1 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд хамаарахгүй 5 байгууллага байна.



Хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлтийг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Боловсролын салбарын 82 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 71 байгууллага, огт илгээгүй 10 байгууллага, хянагдаагүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 86,6%.

Соёлын салбарын 23 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 22 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 95,7%.

Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 16 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага. Улирлын мэдээ илгээлтэд 4 өрхийн эмнэлэг хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 94,1%.

Орон нутгийн төсвийн 48 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 37 байгууллага, огт илгээгээгүй 11 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 77,1%.

20 төрийн сангийн улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 16 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 1 байгууллага, огт илгээгүй 3 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 80%.

Орон нутгийн өмчит 14 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 8 байгууллага, огт илгээгүй 5 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд Ахмадын өргөө хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 61,5%.

Байгууллагын таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг байршуулалтад Орон нутгийн төсөвт байгууллагыг 100% буюу 48 байгууллага, түүврээр боловсролын 20 байгууллага, эрүүл мэндийн 5 байгууллага, соёлын 5 байгууллага нийт 78 байгууллагыг хамруулж хяналт хийхэд 41 байгууллага буюу 52,6% нь мэдээлэл оруулж байршуулсан, 37 байгууллага буюу 47,4% нь мэдээлэл огт байршуулаагүй, шилэн дансанд оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээллэжээ.

Шалгалтад хамрагдсан байгууллагуудаас 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 12 сумын 24 байгууллагын 42 гэрээг татан авч тухайн байгууллагуудаас ирүүлсэн гэрээнүүдийг шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулгахад 8 байгууллагын 11 ширхэг 704,777,521 (долоон зуун дөрвөн сая долоон зуун далан долоон мянга таван зуун хорин нэг) төгрөгийн гэрээг огт байршуулаагүй, 7 сумаас гэрээ огт ирүүлээгүй, батлагдсан төсвөө хөтөлбөр зориулалтын бөөн дүнгээр байршуулснаас тухайн жилийн батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллаар нь харах боломж бүрдээгүй, мэдээлэл байршуулсан байгууллагуудын мэдээлэл шаардлага хангахгүй, оруулсан мэдээллүүдээ өссөн дүнгээр байршуулдаггүй, бэлтгэн нийлүүлэгчийн нэр бичих талбарт гүйлгээний утга бичдэг, гэрээний дүнг буруу байршуулдаг, таван сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа үйлчилгээний гүйлгээг байршуулахаар байхад орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилтийг байршуулдаг зэрэг зөрчлүүд илэрлээ. Тухайн зөрчлийг арилгуулахаар орон нутгийн төсөвт 48 байгууллагын мэдээлэл байршуулдаг албан хаагчидтай утсаар холбогдож мэрэгжил арга зүйгээр ханган ажиллалаа.

Иймд мэдээлэл оруулсан байгууллагууд өөрсдийн байршуулсан мэдээллээ дахин хянах, мэдээллээ огт байршуулаагүй байгууллагууд журмын дагуу мэдээлэл нөхөн байршуулах шаардлагатай.

Орон нутгийн төсөвт 48 байгууллага, түүврээр боловсролын 20 байгууллага, эрүүл мэндийн 5 байгууллага, соёлын 5 байгууллага нийт 78 байгууллагыг хамруулж төсөв байршуулалтад хяналт хийхэд эдийн засгийн ангилалын дагуу задалж байршуулсан 56 байгууллага, хөтөлбөр зориулалтын бөөн дүнгээр байршуулсан 16 байгууллага, байгууллагын батлагдсан төсөв оруулаагүй 6 байгууллага.

Орон нутгийн төсөвт байгууллагыг 100%, боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагууддаас түүврээр авч шалгахад 71,8% нь эдийн засгийн ангиллын дагуу батлагдсан төсвөө байршуулжээ. Иймд бусад байгууллагууд журмын дагуу бүрэн байршуулсан эсэх эргэлзээтэй, байгууллагын батлагдсан төсвийг байршуулдаггүй, бөөн дүнгээр нэр төдий байршуулдаг байдал ашиглагдаж байна.

Байгууллагын батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалаар биш хөтөлбөр зориулалтын бөөн дүнгээр мэдээлэл байршуулсан учраас ямар зардалд хэдэн төгрөг батлагдсан байгааг харах боломжгүй.

Мэдээ байршуулалт оруулсан боловч оруулах мэдээлэл байхгүй гэсэн сонголтоор оруулах ёстой мэдээллийг оруулаагүй хоосон хадгалсан Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Сант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүвэрт хамрагдсан байгууллагуудаас Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг, Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төв, Гучин-Ус сумын Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд байна.

Шалгалтын дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 95,8 хувь, хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 83,7 хувь, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээ байршуулалт 52,6% буюу 704,777,521 (долоон зуун дөрвөн сая долоон зуун далан долоон мянга таван зуун хорин нэг) төгрөгийн гэрээг огт байршуулаагүй, байгууллагын батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу байршуулалт 71,8%-тай, шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах, тайлан илгээх, байршуулсан мэдээллийн чанарт гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, ажилдаа хайнга ханддаг, хугацааг нь тулган мэдээллээ дутуу хагас чанаргүй байршуулдаг, мөн мэдээлэл байршуулалтад тавих удирдлагын болон дотоод хяналтын тавих хяналтууд байхгүйгээс мэдээлэл байршуулалт муу, хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн гүйцэд байршуулахгүй байгаа тул цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах, мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Цаашид шилэн дансны мэдээлэл байршуулалт, улирлын мэдээ илгээлт, мэдээллийн чанар байдалд анхаарч, алдааг дахин давтан гаргасан тохиолдолд дараа улирлаас хариуцсан албан хаагчдад хариуцлага тооцохыг анхааруулж байна.

Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих;

2. Байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон заавал оруулах мэдээллээ бүрэн гүйцэд хуулийн хугацаанд оруулах;

3. Байгууллагууд улирлын мэдээг хуулийн хугацаанд илгээж хэвших;

4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээ байршуулалтыг чанартай бүрэн сар бүр мэдээллэж хэвших;

5. Байгууллагын батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу байршуулах;

6. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах;